



**САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ӨМА-2026/002/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Даланзадгад хот 2026 он</p>	<p>Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: <a href="mailto:usukhbayarts@audit.gov.mn">usukhbayarts@audit.gov.mn</a> Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: <a href="mailto:Khongorzult@audit.gov.mn">Khongorzult@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533552 Цахим хаяг: <a href="mailto:bolormaaja@audit.gov.mn">bolormaaja@audit.gov.mn</a> Аудитор: Э.Жаргал Утас: 70533552 Цахим хаяг: <a href="mailto:jargale@audit.gov.mn">jargale@audit.gov.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.25

№

348

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Орон нутгийн нөөц сангаас хөтөлбөр, арга хэмжээний зардалтай давхардуулан хөрөнгө зарцуулсан, хөтөлбөр арга хэмжээний зардлаас хөрөнгө бэлтгэсэн, анхан шатны баримтаар нотлогдохгүй, ажил гүйлгээ санхүүжүүлсэн, хуулиар хориглосон шагнал, дэмжлэг, урамшуулал олгосон, зориулалт бусаар хөрөнгө зарцуулсан зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16, 4.1.17, 5 дугаар зүйлийн 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.2, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 24 дүгээр зүйлийн 24.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 20 дугаар зүйлийн 20.2.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 12 дугаар зүйлийн 12.1, 12.1.3, 12.1.4, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 1.2, 2.1.5, 7.1 дэх заалтууд, Даланзадгад сумын ИТХ-ын 2025 оны 04/03, 04/06 дугаар тогтоолуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4626250752

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 20,605,934.5 мянган төгрөгийн барилга байгууламж, зам гүүр, тоног төхөөрөмж зэргийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэлд тусгасан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06/03 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн орлогыг 39,618,340.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 36,915,430.4 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Даланзадгад сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09/01 дугаар тогтоолоор 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 86.6 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ЭСӨХБАЯР

# АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		30,598,109.63	32,174,333.87
1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	24,381,806.84	24,000,018.21
1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	700,424.03	1,060,386.97
1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	1,977.08	1,084.75
1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	2,626,208.24	3,949,339.58
1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	28,161	0.0
1.1.7 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	2,859,532.44	3,163,504.36
1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		163,868,448.7	188,914,848.6
1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	163,868,448.7	188,914,848.6
1.2.2.02 Биет хөрөнгө		162,834,098.3	187,455,849.53
1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	1,034,350.4	1,458,999.07
<b>1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>		<b>194,466,558.32</b>	<b>221,089,182.47</b>
2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		620,619.96	1,431,326.51
2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		620,619.96	1,431,326.51
2.1.1.03 Өглөг		27,620.28	3,260.74
2.1.1.04 орлого Урьдчилж орсон	18а, 18б	592,999.68	1,428,065.77
2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		193,845,938.36	219,657,855.96
2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		193,845,938.36	219,657,855.96
2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		27,850,010.69	27,850,010.69
2.2.1.02 /ТӨҮГ/ Өмч /төрийн/		484,597.41	507,410.98
2.2.1.07 Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		19,665.37	0.0
2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		165,327,250.84	191,136,020.24
2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		164,414.04	164,414.04
<b>2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>		<b>194,466,558.32</b>	<b>221,089,182.47</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		98,145,501.78	104,875,788.92
1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		37,465,863.08	35,842,003.15
1.1.1.03.1 Орлогын албан татвар		34,627,261.93	33,021,579.68
1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		35,600,490.39	34,201,439.66
1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(973,228.46)	(1,179,859.98)
1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		925,404.08	866,141.23
1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		1,913,197.08	1,954,282.23
1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	55,785,409.94	69,033,785.78
1.1.1.04.3 Тусламжийн орлого		-	14,377,895.44
1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		4,894,228.75	-
1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	50,891,016.94	58,231,305.27
1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		50,891,016.94	58,231,305.27

1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		42,893,711.96	51,945,747.94
1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		8,415,622.92	11,401,070.78
1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,044,831.65	1,399,808.97
1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		2,315,516.38	4,445,897.96
1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		4,649,636.35	1,040,497.11
1.1.2.01.1.05 Норматив зардал		429,915.64	538,908.76
1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		927,934.32	926,857.38
1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		41,157.63	27,206.45
1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		7,128,747.51	9,973,119.19
1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		17,940,349.55	22,192,381.35
1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		7,997,304.98	6,285,557.33
1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		47,254,484.84	46,644,483.65
1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		6,198,576.31	20,837,123.53
1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		(6,198,576.31)	(20,837,123.53)
1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		41,055,908.53	25,807,360.12

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган  
төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	152,697,316.44	152,697,316.44
1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	92,713.39	92,713.39
1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	152,790,029.83	152,790,029.83
1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	41,055,908.53	41,055,908.53
1.1.1.1 2024 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	193,845,938.36	193,845,938.36
1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	193,845,938.36	193,845,938.36
1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,409.28	1,409.28
1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	193,847,347.64	193,847,347.64
1.5 Өмчид гарсан өөрчлөлт	3,148.20	3,148.20
1.7 Тайлант үеийн үр дүн	25,807,360.12	25,807,360.12
1. 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	219,657,855.96	219,657,855.96

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган  
төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	<b>47,042,585.02</b>	<b>59,399,391.53</b>
1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	37,465,863.08	35,842,003.15
1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	34,627,261.93	33,021,579.68
1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(973,228.46)	(1,179,859.98)
1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	925,404.08	866,141.23
1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	1,913,197.08	1,954,282.23
1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,252,110.90	1,605,447.78
1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	657,529.16	345,821.78
1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	3,557.02	3,012.68
1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,682,493.18	23,557,388.38

1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	4,682,493.18	5,252,163.74
1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	14,377,895.44
1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	3,927,329.20
1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,894,228.75	-
1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	30,056,752.04	39,650,699.25
1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	30,056,752.04	39,650,699.25
1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,682,179.31	30,868,989.12
1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,505,846.71	11,337,448.02
1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,002,150.02	1,450,139.61
1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,376,779.44	4,461,987.96
1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	972,366.83	1,064,402.42
1.1.1.2.01.1.05 Норматив зардал	203,464.39	311,987.66
1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	887,298.15	927,602.59
1.1.1.2.01.1.07 Томилт, зочны зардал	41,157.63	27,206.45
1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,999,781.31	10,084,922.06
1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	693,334.83	1,203,292.37
1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,374,572.73	8,781,710.13
1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	16,985,832.98	19,748,692.28
1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	4,654,488.75	20,130,480.90
1.1.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,654,488.75	20,130,480.90
1.1.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	4,654,488.75	20,130,480.90
1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(4,654,488.75)	(20,130,480.90)
1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	12,331,344.22	(381,788.62)
1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,050,462.61	24,381,806.84
1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,381,806.84	24,000,018.21

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	83,312,880.10	80,121,831.89
3.1.01.1.1 Татварын орлого	38,518,340.00	35,842,003.15
3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	35,802,140.00	33,021,579.68
3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	36,982,000.00	34,201,439.66
3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	32,155,000.00	29,747,763.74
3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	500,000.00	551,379.28
3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	2,127,000.00	1,850,417.06
3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	800,000.00	867,908.19
3.1.01.1.1.1.1.07 Шууд бус орлого	1,400,000.00	1,183,971.40
3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,179,860.00)	(1,179,859.98)
3.1.01.1.1.1.2.01 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,179,860.00)	(1,179,859.98)
3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	1,183,200.00	866,141.23
3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1,100,000.00	756,174.03
3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	8,200.00	7,905.59
3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	75,000.00	102,061.61
3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	1,533,000.00	1,954,282.23
3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,205,000.00	1,605,447.78

3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	1,000,000.00	1,349,204.77
3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	20,000.00	9,733.16
3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	185,000.00	246,509.85
3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	328,000.00	345,821.78
3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	328,000.00	345,821.78
3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	-	3,012.68
3.1.01.1.1.8.3.03 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	-	3,012.68
3.1.01.1.2 Татварын бус орлого	44,794,540.10	44,279,828.75
3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	1,273,870.90	1,162,012.16
3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	1,000,000.00	895,622.98
3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	198,870.90	105,461.22
3.1.01.1.2.1.9 Бусад орлого	75,000.00	160,927.96
3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	39,593,340.00	39,190,487.39
3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих	39,593,340.00	39,190,487.39
3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	3,927,329.20	3,927,329.20
3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	3,927,329.20	3,927,329.20
3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	67,202,504.60	81,265,954.81
3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	43,068,574.90	73,948,098.86
3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,788,149.90	26,088,742.51
3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,288,655.60	8,003,469.47
3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	3,828,468.50	3,761,911.00
3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	3,210,995.50	3,170,129.59
3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	849,498.20	758,364.94
3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	386,399.40	305,791.21
3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	13,294.00	7,272.73
3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,102,426.00	1,051,029.86
3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	709,010.50	692,063.14
3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	83,247.90	80,714.35
3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	71,448.00	70,374.23
3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	71,448.00	56,399.17
3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	167,271.60	151,478.98
3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,504,973.40	4,457,643.93
3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	1,549,451.40	1,256,847.43
3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	3,354,783.40	2,764,756.50
3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	600,738.60	436,040.00
3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	1,426,015.60	864,204.54
3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	135,121.70	69,103.30
3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	771,411.10	542,087.02
3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	50,120.00	41,128.28
3.1.01.2.1.1.4.04 Ном, хэвлэл	8,000.00	250.00
3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	80,000.00	10,000.00
3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	381,362.80	201,635.94
3.1.01.2.1.1.5 Норматив зардал	65,400.00	65,211.40
3.1.01.2.1.1.5.01 Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	400.00	400.00
3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл	65,000.00	64,811.40
3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	1,074,114.00	983,423.69
3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	110,600.00	85,666.20

3.1.01.2.1.1.6.03 Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	20,000.00	7,474.00
3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	943,514.00	890,283.49
3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	33,000.00	14,200.00
3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	33,000.00	14,200.00
3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,384,465.30	10,018,790.14
3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,384,465.30	10,018,790.14
3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	909,100.00	630,769.48
3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	790,000.00	540,747.21
3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	119,100.00	90,022.27
3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,280,425.00	47,859,356.35
3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	10,686,591.00	47,522,041.04
3.1.01.2.1.4.1.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	10,686,591.00	8,331,553.65
3.1.01.2.1.4.1.03 Төсвийн санхүүжилт	-	39,190,487.39
3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	593,834.00	337,315.31
3.1.01.2.1.4.2.04 Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	52,488.00	17,496.00
3.1.01.2.1.4.2.06 Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	342,276.00	125,855.81
3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	199,070.00	193,963.50
3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,133,929.70	7,317,855.96
3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	24,133,929.70	7,317,855.96
3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	16,110,375.50	(1,144,122.92)
3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(16,110,375.50)	1,144,122.92
3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(16,110,375.50)	1,144,122.92
4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	23,794,583.17
5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	22,650,460.25

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	2025 оны 12-р сарын 31
1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	14,452,721.24
1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,452,721.24
1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	14,452,721.24
1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	14,452,721.24
1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	14,452,721.24
1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,164,157.31
1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,755.33
1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	284,808.60
1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,452,721.24
1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	1,731,025.40
1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,725,675.40
1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,300,272.82
1.1.1.2.1.1.1.1 Үндсэн цалин	61,669.92
1.1.1.2.1.1.1.2 Нэмэгдэл	37,234.88
1.1.1.2.1.1.1.4 Урамшуулал	1,201,368.02
1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	161,767.90

1.1.1.2.1.1.2.1 Тэтгэврийн даатгал	104,937.74
1.1.1.2.1.1.2.2 Тэтгэмжийн даатгал	12,954.16
1.1.1.2.1.1.2.3 ҮОМШӨ-ний даатгал	15,433.35
1.1.1.2.1.1.2.4 Ажилгүйдлийн даатгал	5,757.06
1.1.1.2.1.1.2.5 Эрүүл мэндийн даатгал	22,685.58
1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	23,659.89
1.1.1.2.1.1.4.1 Бичиг хэрэг	500.00
1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	21,634.89
1.1.1.2.1.1.4.6 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,525.00
1.1.1.2.1.1.5 Нормативт зардал	1,600.00
1.1.1.2.1.1.5.2 Хоол, хүнс	1,600.00
1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	2,800.00
1.1.1.2.1.1.6.1 Багаж, техник, хэрэгсэл	2,800.00
1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,000.00
1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,000.00
1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	216,574.80
1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	216,574.80
1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,350.00
1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	62,552.66
1.1.1.2.1.4.2.8 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	62,552.66
1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,664,493.19
1.1.1.2.2.1 Дотоод эх үүсвэрээр	12,664,493.19
1.1.1.2.2.1.4 Бусад хөрөнгө	12,664,493.19
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 40.5 сая төгрөгийн 2 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 40.5 сая төгрөгийн 2 алдааг залруулсан. Үүнд:

- Тайлант онд гүйцэтгэсэн 5 ажлын хяналтын зардал 7.0 сая төгрөгийг бүртгэлд тусгаагүй,
- Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас хийгдсэн 33.5 сая төгрөгийн дулааны шугам сүлжээний засварыг бүртгэлд тусгалгүй зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" 20 дугаар зүйлийн 20.2-д "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", санхүүгийн тайлангийн толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 503.3 сая төгрөгийн 10 зөрчил<sup>2</sup> илэрснээс 240.6 сая төгрөгийн 5 зөрчилд алдаа зөрчлийг таслан зогсож, давтан гаргахгүй байх 5 албан шаардлага, 262.7 сая төгрөгийн 5 зөрчилд хууль хэрэгжүүлэн ажиллах 5 зөвлөмж өгч ажилласан.

<sup>1</sup> Мэдээллийг тусгаагүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 64.3 сая төгрөгөөр их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

### **3.1 Төлбөрийн акт**

Аудитын явцад төлбөрийн акт тогтоогоогүй.

### **3.2 Албан шаардлага**

**Илрүүлэлт 1:** "Хотын залуус" хөтөлбөрийн зардлаас И-спортыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээний зардалд 10.5 сая төгрөг, "Соёлын дархлаа" хөтөлбөрийн зардлаас 17.5 сая төгрөгийн салют худалдан авч төсвийн хөрөнгийн зориулалт бусаар үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Даланзадгад сумын ИТХ-ын 2025 оны 04/03, 04/06 дугаар тогтоолоор баталсан уг хөтөлбөрүүдийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлтэй тус тус нийцэхгүй байна.

**Илрүүлэлт 2:** "Соёлын дархлаа" хөтөлбөрийн зардлаас 8.2 сая төгрөгийн бүжгийн хувцас авахад дэмжлэг үзүүлж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно" тус тус нийцэхгүй байна.

**Илрүүлэлт 3:** Хөтөлбөр, арга хэмжээний зардлаас шинэ бүтээл, ном хэвлүүлэхэд 39.3 сая төгрөгийн дэмжлэг олгож төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.3-д "хэвлэлийн захиалгын төлбөр" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Илрүүлэлт 4:** Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас шилдэг байгууллага шалгаруулан 6.0 сая төгрөгийг улсын төсвийн байгууллагад олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7.1-д "төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Илрүүлэлт 5:** Тайлант онд хөтөлбөр, арга хэмжээний зардлаас 226.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16-д "хөтөлбөр" гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг", 4.1.17-д "арга хэмжээ" гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг", 14 дүгээр зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**Илрүүлэлт 1:** Тайлант онд Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, Хадгаламжийн хүүгийн орлого, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар, Хүү торгуулийн орлого, Төсөвт газрын өөрийн орлого, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг 2,702.9 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн орлогыг суурь тооцоололд үндэслэн бодитой тооцож, төлөвлөн ажиллах.

**Илрүүлэлт 2:** Тайлант онд Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас эмчилгээний дэмжлэгт 88 иргэнд 322.3 сая төгрөг олгохдоо зөвхөн дэмжлэг хүссэн иргэний нэхэмжлэх, өвчний түүхийг үндэслэн олгосон байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-д "Ажил үүргээ биелүүлэх нөхцөлийг нь сайжруулах зорилгоор ажил олгогчоос ажилтанд олгож байгаа дараах шууд бус орлогыг албан татвар ногдох орлогод хамруулахгүй", 11.2.4-д "эрүүл мэндийн байгууллагад төлсөн эмчилгээний зардалд зориулж олгосон тусламж, дэмжлэг" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Цаашид Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дэх заалтыг хэрэгжүүлэн орлогын албан татварыг суутган тооцож ажиллах.

**Илрүүлэлт 3:** Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас хөтөлбөр, арга хэмжээтэй давхардуулан золбин нохой муурын тоо толгойг бууруулах, малын сэг зэм, орчны ариутгал, халдваргүйтгэл хийх ажлын зардалд 33.3 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7.1-д "төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Хөтөлбөр, арга хэмжээний зардалтай давхардуулан зарцуулалт хийхгүй байх, төлөвлөлтийг холбогдох хууль, тогтоомжтой уялдуулан, бодиттой тооцож, төлөвлөж ажиллах.

**Илрүүлэлт 4:** Сумын ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн Б/01 дугаар "Сумын 2025 оны төсвийн тодотгол батлах тухай" тогтоолоор 10 дэд хөтөлбөр, 46 арга

хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулсан нь Аймгийн Засаг даргын хэрэгжүүлж буй хөтөлбөртэй уялдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5-д "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон түүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ, ажил, үйлчилгээг тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх аль нэг хөтөлбөрт хамруулсан байна", Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т "Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч, Засаг даргыг томилогдсоны дараах хоёр сарын дотор багтаан боловсруулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох хууль, тогтоомжтой уялдуулан ажиллах.

**Илрүүлэлт 5:** "Боловсролын ундрага" хөтөлбөрийн зардлаас ЕБС-ын сурагчид, төрийн албан хаагчид БНСУ, БНХАУ, ӨМӨЗО-д туршлага судлах зардалд 80.0 сая төгрөг зарцуулсан боловч жагсаалтад байгаа албан хаагчид бүрэн хамрагдсан эсэх нь баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Хөтөлбөрийн хүрээнд гадаад улсад туршлага судалсан албан хаагчдын хилээр нэвтэрсэн эсэхийг нотлох баримтыг бүрдүүлэн ажиллаж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



